байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгаж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгож хөгжүүлэх шаардлага тулгаран гарч ирж байна.

Энэ бүхнээс харахад хилийн боомтын аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хууль, эрх зүйн актыг судлан хэлэлцүүлэн нэгтгэн нэг ойлголтонд хүрэх цаг болсон байна.

***У.Мөнхбат*** *-Хууль сахиулахын удирдлагын академийн*
*821 дүгээр да.мжааны суралцагч дэд хурандаа*

## ХИЛ ДАМНАСАН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ХИЛИЙН ОТРЯДЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА

***Хураангуй:*** *Энэхүү илтгэлээр хил дамнасан гэ.ит хэрэгтэй тэмцэх хшийн аюулгүй байдал хил хамгаалалтад тулгамдаж буй зарим асуудлыг хууль эрх зүйн хүрээнд судлаж, цаашид анхаарах асуудлыг хөндөж тавихыг зорилоо.*

***Түлхүүр үг:*** *Хил дамнасан гэмт хэрэг; хилийн отрядын ажпллагаа, хуулъ бус цагаачлал*

Орчин үед гэмт хэрэг нь нэг улсын нутаг дэвсгэрээс хальж, хоёр ба түүнээс дээш олон улсын нутаг дэвсгэр дамнан үйлдэгдэх болсон. Гэмт хэргийн бүлэглэлүүд даяаршил, интернет зэрэг орчин үеийн үйлдлүүдээс ашиг олохыг эрмэлзэж, гэмт үйлдлийн явцдаа хүч хэрэглэх, мөнгө угаах, төрийн албан тушаалтнуудыг худалдан авах зэргээр улс орны санхүү, эдийн засагт ихээхэн хохирол учруулсаар байна. Хил орчмын нутаг дэвсгэрт дамын наймаа, хууль бус цагаачлал, аллага, хядлага зэрэг гэмт хэрэгтэй тэмцэхээр хязгаарлагдахгүй, улс орны нутаг дэвсгэрийн бусад хэсгүүдэд түгээмэл гардаг аллага, дээрэм, хулгай гэх мэт хэргүүдтэй ч тэмцэх болдог. Гэвч зарим тохиолдолд эдгээр гэмт хэргүүд нь хил залгаа улсуудын ашиг сонирхлыг хөнддөг юм. Тухайлбал зэргэлдээ улсын нутаг дэвсгэрт нөгөө улсын иргэд тээврийн хэрэгсэл, мал хулгайлах, дээрэм хийх болон бусад гэмт хэргүүдийг хил зөрчин үйлддэг. Гэмт хэрэгтнүүд хэрэг үйлдсэнийхээ дараа өөрийн улсын нутаг дэвсгэр рүү буцаж ордог, зарим тохиолдолд гэмт хэрэгтнүүд хариуцлага, ялаас мултрахын тулд зэргэлдээ улсын нутаг дэвсгэр рүү нууцаар нэвтрэн ордог байна. Энэ төрлийн гэмт хэргүүд нь тухайн нутаг дэвсгэрт нь гэмт хэрэг үйлдэгдсэн орны хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэгдэх ёстой. Мөн эдгээр гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор гэмт хэрэгтнүүдийг буцааж өгч байх болон иргэн, эрүүгийн хэргийн

салбарт харилцан туслалцаа үзүүлэх хоёр талын гэрээг зэргэлдээ улсуудтай байгуулдаг. Хил орчмын нутаг дэвсгэрт үйлдэгддэг гэмт хэргүүд нь олон улсын болон үндэсний хууль тогтоомж, янз бүрийн салбарт улс орнууд хамтран ажиллах зарчим, хүний эрх, эрх чөлөө, улс, иргэдийн бусад ашиг сонирхлыг алдагдуулдаг юм. Олон улсын эрх зүйн онол, практикт эдгээр гэмт хэргүүдийг "Олон улсын гэмт хэрэг" гэж томьёолдог. Олон улсын гэмт хэрэг гэдэг нь дэлхийн олон улсын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн аюултай гэмт үйлдэл юм.

Олон улсын гэмт хэрэгт:

- Алан хядах ажиллагаа терроризм
- Хүн барьцаалах
- Хүний наймаа
- Цахим гэмт хэрэг
- Боолчлол болон боолын худалдаа
- Хуурамч мөнгө үйлдвэрлэх. тараах
- Мансууруулах бодис, хар тамхины наймаа
- Цөмийн материалын худалдаа
- Порно материал үйлдвэрлэлт, борлуулалт
- Хууль бус цагаачлал
- Хууль бусаар түүх дурсгалын үнэт зүйлсийг хилээр оруулах. гаргах зэрэг гэмт хэргүүд орно[1].

Хил дамнасан малын хулгай Монгол- Тувагийн чиглэлд олон жил гарч байгаа төдийгүй энэ төрлийн хэрэг Монгол-Хятадын хилийн хэсэгт ч шинээр гарах болсон Хятадын талаас Монголоор дамжуулан амьд барааг "хүнийг" гуравдагч оронд гаргах явдал газар авах шинжтэй төдийгүй хууль бус цагаачлагчдын шинэ замыг хойд Солонгосын иргэдэд зааж өгч байна. Хар тамхийг Европ руу дамжуулан нэвтрүүлэх гол суваг болох магадлал бий. Хоёр ба түүнээс дээш усын иргэд оролцсон контрбандын зөрчил ч улам бүр далайцтай болж хар тамхи мансууруулах бодис, шонхор шувуу, алт, машин, түүхийн ховор дурсгалт зүйлс, олдвор, хуурамч мөнгө үйлдвэрлэн хил давуулан оруулах, гаргах болон дамжуулан тээвэрлэх боллоо.

**А. Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх.** Улс бүр өөрийн болон бусад улсын аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй төрөл бүрийн бараа, материал, аюултай бодисыг өөрийн нутаг дэвсгэр рүү оруулах, гаргахад улсынхаа хил дээр тодорхой хэмжээний хязгаарлах арга

[1] *Ц.Ганболд* Хилийн төлөөлөгчийн ажиллагааг сайжруулах арга зам. Докторын дисертаци -УБ., 2008. 26 дахь тал

хэмжээнүүдийг авдаг. Улсын хилээр бараа материал, үнэт зүйлсийг хууль бусаар нэвтрүүлэх үйлдлийг дэлхий дахинд "контрбанд" буюу “улсын хилээр нууцаар. гаальгүй дамын наймаа хийх үйлдэл”. Өөрөөр хэлбэл албан тушаалын байдал болон хуурамч баримт бичгээр их хэмжээний үнэт зүйл, бараа бусад эд юмсыг хууль бусаар гаалийн хяналт шалгалтаас нуун улсын хилээр нэвтрүүлэх гэж тодорхойлсон байдаг.Хил дамнасан гэмт хэрэг нь олон улсын шинж бүхий хуулийн зөрчил бөгөөд нэг зэрэг үндэсний болон олон улсын хууль зөрчсөн алан хядах ажиллагаа үйлдэх, хар тамхинд донтох зэрэг нийгмийн аюултай үзэгдлүүдийн амьдрах, оршин тогтнох шим тэжээлтэй хөрсийг бүрдүүлэгч үйлдэл юм. Одоо хүртэл хил дамнасан гэмт хэргийн талаар олон улсын гэрээ хэлэлцээр байхгүй бөгөөд зөвхөн хар тамхи. түүх соёлын үнэт зүйлс, хуурамч мөнгөн тэмдэгт болон архи спиртийн төрлийн барааг хууль бусаар оруулах, гаргах үйлдэлтэй холбоотой гэрээ хэлэлцээрүүд байгуулагдсан. Мансууруулах бодисын хил дамнасан хууль бус наймаа нь олон улсын харилцаа, үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм эдийн засагт асар их хохиролтойбайдаг. Монгол улс нь “мансууруулах бодисын тухай” 1961оны конвенцид 1991онд нэгдэн орсон. Уг конвенцийн 1-дүгээр бүлгийн 36-дугаар зүйлд “тухайн конвенцийн заалтуудыг зөрчин мансууруулах бодис хууль бусаар оруулах, гаргах нь мансууруулах бодис дамлан наймаалах гэмт үйлдэл мөн“ [1]гэж заасан. Мансууруулах бодисын хууль бус наймаанаас олж буй асар их ашиг орлогын ихэнх хэсэг нь олон улсын алан хядах байгууллагыг санхүүжүүлэх, улс орны хууль ёсны засаглалыг устгахад зориулагддаг байна. Улсын хилээр түүх дурсгалын үнэт зүйлс, олдворуудыг хууль бусаар хил давуулан худалдаалах явдал ч их гарсаар байна. Түүх дурсгалын үнэт зүйлс, олдворуудыг ч хулгайлах, дээрэмдэх, нууцаар ухаж авах зэрэг хууль бус аргуудаар олборлон хил давуулан худалддаг хэрэг цөөнгүй гарсаар байна. Улсын хилээр хууль бус аргаар гадаадад үйлдвэрлэсэн хуурамч мөнгөн тэмдэгт оруулах гэмт үйлдэл гарсаар байна. Улсын хилээр архи спиртийн төрлийн ундааг оруулах, гаргахыг хуулиар хориглосон бөгөөд “архи спиртийн барааны хууль бус наймаатай тэмцэх олон улсын конвенци" -д Хятад улс нэгдэн ороогүй зэрэг нь энэ төрлийн гэмт хэрэгтэй Монгол улсын зүгээс тэмцэл хийхэд хүндрэл учруулсаар байна[1] [2].

**Б. Терроризм түүнтэй тэмцэх.** Олон улсын терроризм гэж гэмт хэрэгтэн ба хохирогч нь хоёр ба түүнээс дээш гүрний иргэд боловч гэмт

[1] Архи спиртийн төрлийн барааны хууль бус наймаатай тэмцэх олон улсын конвенци. 1991.36 дугаар зүйл

[2] *Д.Жавхланцогт.* Контрбанд. —УБ., 2010. 31 дэхтал

хэргийг хилийн чанадаас үйлдсэн бол, олон улсын хамгаалалтад байдаг этгээдийн эсрэг алан хядах ажиллагаа үйлдсэн бол, гэмт хэргийг нэг орны нутаг дэвсгэр дээр бэлтгээд нөгөө улсад гүйцэтгэсэн бол, алан хядагч нэг гүрэнд алан хядах ажиллагаа үйлдээд нөгөө улсад нуугдсанаар түүнийг шилжүүлэн өгөх тухай асуудал гарсан зэрэг олон улсын шинж чанар бүхий үйлдлийг хэлнэ гэжээ.

Олон улсын терроризмын тухай ойлголтыг маш өргөн утгаар авч үзвэл: гэмт хэргийн шинж чанарыг агуулсан, юугаар ч зөвтгөх үндэслэлгүй үйл явдал, терроризмыг аль ч улс оронд, хаана ч үйлдсэн бай ялгаатүй улс үндэстэнд, улс гүрний найрсаг харилцаа төр, улсын аюулгүй байдалд аюул, занал агуулж л байгаа бол тэдгээрийг олон улсын терроризм гэж үзэж болох юм гэж мөн тодорхойлжээ.

Олон улсын алан хядах ажиллагаа нь олон улсын харилцаанд аюул учруулж. олон улсын байдлыг тогтворгүй болгон зарим тохиолдолд шинэ улсыг бий болгох улмаар улсын хилийг шинээр тогтооход чиглэгддэг. Үүний үр дүнд аюулын голомт бий болж, зэвсэгт мөргөлдөөн үүсгэснээр ихээхэн хохирол, хөнөөлд хүргэдэг. Улсын хил ихэнх тохиолдолд алан хядагчид бусад улсын нутаг дэвсгэрт нууцаар нэвтрэн орох. алан хядах ажиллагаа явуулах, зэвсэг галт хэрэгсэл, дэлбэрэх болон хорт. цацраг идэвхт бодисуудыг нэвтрүүлэн дамжуулах суваг болон ашиглагддаг. Олон улсын алан хядах ажиллагаатай тэмцэхэд дараах үүргүүдийг биелүүлдэг:

> Манай нутаг дэвсгэр рүү нууцаар нэвтрэх суваг, замыг хаах;

> Хууль сахиулах бусад байгууллагуудтай хамтран улсын хил. шалган нэвтрүүлэх боомтоор алан хядах байгууллагын гишүүд. холбоо бүхий этгээдийг нэвтрүүлэхгүй байх;

> Холбогдох байгууллагуудтай харилцан ажиллаж нисэх онгоц болон бусад тээврийн хэрэгслийг алан хядах ажиллагааны зорилгоор барьцаалуулахгүй, олзлуулахгүй, ашиглуулахгүй байх арга хэмжээг авах;

> Алан хядах бүлэглэлүүд манай нутаг дэвсгэрт явуулж болзошгүй ажиллагааг нь цаг алдалгүй таслан зогсоох зорилгоор мэдээ мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх;

> Хилийн цагийн байдал шаардсан тохиолдолд алан хядагчдыг илрүүлэх, устгах зорилгоор оперативын, дэглэмийн, тусгай цэргийн ажиллагаа явуулах;

> Хууль хяналт хүчний байгууллагуудтай хамтран -зэвсэглэсэн алан хядагчдыг устгах, баривчлах ажиллагаанд бие бүрэлдэхүүнийг сургах;

> Алан хядагчидтай тэмцэж буй үр дүнтэй арга, туршлагыг судлах, тэдэнтэй тэмцэх шинэ арга ажиллагааг боловсруулах

> Хил орчмын нутаг дэвсгэрийн оршин суугчдын дунд алан хядлага. түүний аюулын талаар ухуулга, сурталчилгааны ажил хийх;

> Алан хядагчдыг хилээр манай улсын нутаг дэвсгэр рүү илээр ба нууцаар нэвтрэх, зэвсэг галт хэрэгсэл, хориотой бараа нэвтрүүлэх ажиллагааг саатуулах[1]

**В. Хууль бус цагаачлалтай тэмцэх.** Хууль бус цагаачдын хяналтгүй урсгал нь улс орны нийгмийн халамж, хүн амын хангалтын бүтэц, хэв журам сахиулах ажиллагааг бусниулах аюултай. Хүмүүс өөрийн эх орныг янз бүрийн шалтгаанаар орхин гардаг бөгөөд гол төлөв дайн байлдаан, иргэний мөргөлдөөний улмаас өөрсдийн амь насаа хамгаалах, амьдралын таатай нөхцлийг эрэх, өөрийн хувийн боломжоо илүү ашиглах бололцоог хайх зэргээс үүдэлтэй байдаг. Улс орны үндэсний эрх ашиг, аюулгүй байдалд тухайн улсын нутгаар дайрч өнгөрөх хууль бус цагаачид, дүрвэгсдийн асуудал ихээхэн нөлөөлдөг[1][2].

Өнөө үед дүрвэгсдийн асуудал дэлхий дахинд, тэр тусмаа Азийн бүс нутагт хурцдаж байна. Одоогоор дэлхийд 32 сая дүрвэгсэд байгаагаас ОХУ-д л гэхэд 800.000 хүн эх орноосоо дүрвээд байгаа аж.

Хөрш хоёр гүрний дотоод улс төрийн байдал хурцадснаас эдгээр орнуудаас мөн тэрчлэн гуравдагч орноос ялангуяа Хятадаар дамжин хойд Солонгосоос дүрвэгсэд манайд орж ирэх магадлал их байна. Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенцийг НҮБ 1951 онд батласан бөгөөд энэ конвенцид дэлхийн 121 улс нэгдээд байна. Манай улс энэ конвенцид нэгдээгүй байгаа ч “хөрш орноос дүрвэгсэд олноор орж ирэх нь Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдалд эсрэг нөлөөлөх гадаад хүчин зүйл мөн[3]" гэж Монгол улсын аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан

**Шийдвэрлэх арга зам:**

1. Эрүүгийн хууль, зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах.
2. Хил хамгаалалтын дүрэмд хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх талаар заалт оруулах.
3. Хилийн төлөөлөгчийн ажиллагаанд дээрх гэмт хэргийг шийдвэрлэх эрхийг нэмэгдүүлэх.
4. Албаны бэлэн байдлыг хангах удирдамжинд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх арга ажиллагааг боловсронгуй болгох.

[1] *Х.Түмэн.* Олон улсын алан хядлага терроризмтай тэмцэх нь. -УБ. 2009. 42 дахь тал
[2] *Д.Жавхланцогт* Улсын хилээр зэвсэггүй бөөн иргэд нэвтэрсэн үеийн ажиллагаа". -УБ. 154 дэх тал
[3] *Ц.Одбаяр* Хилийн аюулгүй байдал ба орчны нөлөөлөл. -УБ . 2009. 38 дахь тал

5. Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагаа уялдаа холбоог сайжруулах.

6. Хилийн тагнуулын албыг буцаан хил хамгаалах байгууллагад шилжүүлэх.

***Б. Түвшинтулга*** *- Хууль сахиулахын уйирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, ахмад*

## УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТӨРӨЛ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

***Хураангуй:*** *Энэхүү илтгэлээр улсын хил хамгаалалтын төрлийг нэмэгдүүлэх, боловсронгуй болгох зарим асуудлыг онолын хувьд судлаж, улсын хил хамгаалалтад нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлохыг хүслээ.*

***Түлхүүр*** *үг: Улсын хил хамгаалалт, улсын хил хамгаалалтын төрөл, онцгой нөхцөл байдал үүссэн үеийн хил хамгаалалт*

Манай улс нь ОХУ болон БНХАУ-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд хүч хэрэглэхгүй, хүчээр сүрдүүлэхгүй байх. харилцан үл довтлох гэсэн хэдий ч дэлхийн улс орнуудын дунд эдийн засгийн болон газар нутаг, шашин шүтлэгийн үзэл баримтлалын сөргөлдөөн өдрөөс өдөрт хурцдаж, улс хоорондын зөрчил нь хүрээгээ тэлж, тив хоорондын зөрчил зөрөлдөөн болон хувирч байна[1].

Дэлхий ертөнцөд даяарчлалын нөлөөгөөр гарч буй олон өөрчлөлтүүд болох хил дамнасан гэмт үйлдэл, нийгэм эдийн засгийн хямрал. байгаль экологийн өөрчлөлт. хүн амын амьжиргааны түвшингийн доройтол, хялбар аргаар мөнгө олох хууль бус ажиллагаа, хязгаар нутгаас төв рүү чиглэсэн нүүдэл зэргээс үүдэн гарч буй сөрөг үзэгдлүүд нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт хурцаар илрэх болов. Улсын хилээр мансууруулах бодис, зэвсгийн наймаа хийх, зохион байгуулалттай бүлгийн үйл ажиллагаа идэвхжих зэрэг нь хил хамгаалах байгууллагын албаны үйл ажиллагааг шинэ нөхцөл байдалд, шинэлэг арга хэлбэрүүдээр, эрчимтэй, далайцтай явуулахыг шаардаж байна.

Ийм нөхцөл байдал нь эдийн засгийн хувьд сул дорой манай улсад сөргөөр нөлөөлж болох юм. Улс орны улс төрийн тогтворгүй байдал нь улсын хил хамгаалалтад сөргөөр нөлөөлж, хил хамгаалалтын төрлийг нэмэгдүүлж, боловсронгуй болгох зайлшгүй шаардлага урган гарч байна.

Өнөөгийн байдлаар хил хамгаалах байгууллага нь:

> Ердийн.

[1] Монгол Улс БНХАУ хооронд байгуулсан гэрээ. 2002.